

Нягтлан бодогчийн ёс зүйн асуудалд

Code of Ethics for Professional Accountants

О. Пүрэвдорж¹, О. Нүржигмаа²

Хураангуй

Нягтлан бодох бүртгэлийн мэргэжил нь олон нийтийн төлөө үйлчлэх үүрэг хариуцлагыг хүлээдэг учраас энэ мэргэжилд мэргэжлийн ёс зүй зайлшгүй байх шаардлагатай. Нягтлан бодогч нь ёс зүйн дүрмийг баримтлан хууль, дүрэм журам, стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэн толилуулж мэдээлэл хэрэглэгчдийг үнэн зөв бодитой мэдээллээр хангах үүрэг хүлээдэг. Энэхүү судалгааны ажилд манай улсад мөрдүүлж буй мэргэжлийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт; төрийн байгууллагуудаас аж ахуйн нэгж, байгууллагуудад хийсэн санхүүгийн хяналт, шалгалтын үр дүн; их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд хийсэн ёс зүйн хичээлийн талаарх судалгаа, мэргэжлийн нягтлан бодогчдоос авсан асуулга зэрэг судалгааны үр дүнг харуулж дүгнэлт өгсөн болно.

Түлхүүр үгс: ёс зүй, ёс суртахуун, хяналт, шалгалт

Abstract

Accountants have a great deal of responsibility to the public, therefore professional ethic is necessary in this profession. Accountant has responsibility to their clients to provide accurate accounting records and financial statements according to the accounting standard, law and regulations followed by codes of ethics. This study also to demonstrate the implementation of code of ethics for professional accountants in our country. Inspection result carried out by the government agencies to private companies and survey on university programs on the subject of code of ethics as well as questionnaires from professional accountants.

Keywords: Ethics, Moral, Monitoring, Verification

¹ ХҮИС-ийн Сургалтын албаны дарга
E-mail: purevdorj.o@nucb.edu.mn

² ХҮИС, НББ-ийн тэнхим
E-mail: nurjigmaa@nucb.edu.mn

Удиртгал

Нягтлан бодох бүртгэл (НББ) нь аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын санхүүгийн мэдээллийг тооцон хэмжих, боловсруулах, нэгтгэн дүгнэх, тайлагнах үүрэгтэй бөгөөд энэ үүргээрээ дамжуулан мэдээлэл хэрэглэгчдийг эдийн засгийн хувьд шийдвэр гаргахад шаардлагатай үнэн зөв, бодитой мэдээллээр хангах зорилгыг хэрэгжүүлдэг. Иймээс энэ мэргэжил нь олон нийтийн ашиг сонирхолын төлөө үйлчлэх үүрэг хариуцлага хүлээдэг. Олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалж үнэнч, шударгаар ажиллахын тулд хууль, дүрэм, тогтоосон стандартын хүрээнд үйл ажиллагаа явуулах ёстой. Эдгээр тогтоосон дүрэм, журмын нэг нь “Нягтлан бодогчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм” юм. Ёс зүйн дүрмийн гол зарчим нь нягтлан бодогч нар хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж үнэнч, шударгаар санхүүгийн тайлан мэдээг бэлтгэн толилуулах, нягтлан бодогчдын гаргасан тайланд хараат бусаар үнэлэлт дүгнэлт өгөх явдал юм.

Манай улсын хувьд олон улсын, төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагуудаас батлан гаргасан НББ-ийн мэргэжилтний баримтлах ёс зүйн дүрмүүдийг нягтлан бодогч нар өөрсдийн үйл ажиллагаанд мөрдлөг болгож байна. Хэдийгээр ёс зүйн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах шаардлагатай боловч байгууллагын хөрөнгө мөнгө шамшигдуулах, санхүүгийн анхан шатны баримтыг хуурамчаар үйлдэх, санхүүгийн болон татварын тайланг хуурамчаар гарган татвар төлөлтөөс зайлсхийх зэрэг ёс зүйн зөрчлүүд гарсаар байна.

Үүний жишээ болгож зарим нэг тоо мэдээг авч үзвэл татварын албанаас хийсэн 8 жилийн хяналт шалгалтын үр дүнгээр

нийт 51,306 (давхардсан тоогоор) ААНБ-д хяналт, шалгалт хийсний 82.3% буюу 42,216 нь зөрчилтэй байснаар 31.7 их наяд төгрөгийн зөрчлийг илрүүлж 2.9 их наяд төгрөгийн төлбөр ногдуулсан байна.

Төрийн аудитын байгууллагын хийсэн санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар сүүлийн 10 жилийн нийт дүнгээр 36,581 санхүүгийн тайлангийн аудит хийсний 16.4%-д нь зөрчил илэрсэн байна. Санхүүгийн хяналт шалгалтаар 2016-2019 онуудад нийт 2,810 албан шаардлага; 9,790 акт; 991,854.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн байна. Мөн 2015 оны байдлаар Татварын ерөнхий газарт 114,335 ААНБ бүртгэлтэйгээс татварын тайлан гаргасан нь 84,958 ААНБ-ын 34,218 буюу 40.2% нь “Х” тайлан гаргажээ. “Х” тайлан гэдэг нь хууль бус нэр томъёо бөгөөд үүний цаана татвар төлөхөөс зугтагч олон хуулийн этгээд байдаг болохыг “Ил тодын тайлан” харуулсан (ДБ & МУСЯ, 2017).

2007 онд хэрэгжсэн татварын өршөөлийн хуулиар 4.5 их наяд төгрөг улсын төсөвт төвлөрсөн бол 2015 онд хэрэгжүүлсэн Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 34.7 их наяд төгрөгийн хөрөнгө, орлого ил болж, 8.3 их наяд төгрөгийн татвар, 2.5 их наяд төгрөгийн торгууль, алдангиас тус тус чөлөөлсөн байна. Энэхүү орлогыг ил болгохтой холбоотойгоор иргэд, ААНБ-ууд 21,275 санхүүгийн тайлан, 89,394 татварын тайлан, 4,165 нийгмийн даатгалын тайлан, 8,140 гаалийн нөхөн мэдүүлгийг холбогдох байгууллагад хүргүүлж, 647 төрлийн эд хөрөнгийн болон 744 хуулийн этгээдийн бүртгэлд 1,176 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна (Тунгалаг, 2015).

Иймээс нягтлан бодогчдын ёс зүйн асуудал НББ-ийн салбарын тулгамдсан

асуудал болж байгаа бөгөөд үүнийг судлах хэрэгцээ шаардлага зайлшгүй гарч байна.

Мэргэжлийн ёс зүйн дүрэм мөрдүүлдэг төрийн бус байгууллагуудын судалгаа

Монголын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авч ёс зүйн тангараг өргөсөн нягтлан бодогчдын судалгаа

Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт (ММНБИ) нь мэргэшсэн нягтлан бодогч болох шалгуурыг хангасан нягтлан бодогчдод зэрэг олгодог бөгөөд ёс зүйн тангараг өргүүлэн гишүүнчлэлд хамруулан ёс зүйн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг шаарддаг (Хүснэгт 1).

“Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн 13.2-т мэргэшсэн нягтлан бодогч нь жил бүр дээрх зарчмууд болон ёс зүйн дүрмийн шаардлагыг хэрхэн хангаж ажилласан тухайгаа илэрхийлсэн өөрийн үнэлгээний тайлан (Ёс зүйн тайлан)-г гаргаж, институтэд ирүүлэх үүрэгтэй гэсэн заалт байдаг. Мэргэшсэн нягтлан бодогч нь

энэхүү үүргээ хэрхэн гүйцэтгэж байгааг Хүснэгт 2-т харуулав.

2016 оны 4,080 гишүүнээс 3,613 гишүүн ёс зүйн тайлан ирүүлэх ёстойгоос 1,777 гишүүн буюу 49.2% нь ёс зүйн тайлангаа ирүүлсэн байна. 2017 онд 3,832 нягтлан бодогч ёс зүйн тайлан ирүүлэхээс 1,685 буюу 44% нь тайлангаа ирүүлсэн байна. 2018 онд нийт ёс зүйн тайлан ирүүлэх ёстой гишүүдийн 52.5% нь тайлангаа ирүүлсэн бол 2019 онд 50% нь ёс зүйн тайлан ирүүлсэн байна. 2020 оны байдлаар нийт гишүүдийн 66.4% нь ёс зүйн тайлангаа ирүүлсэн байна. Ёс зүйн тайлан ирүүлсэн байдлыг байршлаар нь авч үзвэл орон нутгийн гишүүд 85%-90% орчим хувьтай ёс зүйн тайлангаа ирүүлсэн байна.

ММНБИ мэргэшсэн нягтлан бодогчид болон аудитын компаниудын талаар ирсэн санал, гомдлыг хүлээн авч зохих хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэж байна.

2014-2020 оны хооронд ММНБИ-ийн

Хүснэгт 1. Мэргэшсэн нягтлан бодогчид, аудитын компани, аудиторудын тоо

№	Үзүүлэлт	1993-2016	2017	2018	2019	2020	Нийт
1	Эрх авсан гишүүд	3,808	174	165	357	227	4,731
2	Аудитын компани	141	(3)	(1)	(5)	6	138
3	Эрх авсан аудитор	839	98	55	73	109	1,174

Эх сурвалж: Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт


Хүснэгт 2. Мэргэшсэн нягтлан бодогчийн ёс зүйн тайлан ирүүлсэн байдал

№	Салбар	2016				2017			
		Нийт гишүүн	Тайлан өгөх	Тайлан өгсөн	Хувь	Нийт гишүүн	Тайлан өгөх	Тайлан өгсөн	Хувь
1	Улаанбаатар	2,653	2,400	734	30.5%	2,742	2,537	584	23.0%
2	Орон нутаг	1,427	1,216	1,043	85.8%	1,512	1,295	1,101	85.0%
	Нийт	4,080	3,616	1,777	49.2%	4,254	3,832	1,685	44.0%

№	Салбар	2018				2019			
		Нийт гишүүн	Тайлан өгөх	Тайлан өгсөн	Хувь	Нийт гишүүн	Тайлан өгөх	Тайлан өгсөн	Хувь
1	Улаанбаатар	2,821	2,618	863	33%	2,877	2,785	849	30.5%
2	Орон нутаг	1,598	1,354	1,222	90.3%	1,715	1,425	1,256	88.2%
	Нийт	4,419	3,972	2,085	52.5%	4,592	4,210	2,105	50.0%

Эх сурвалж: Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт

Зураг 1. ММНБИ-д ирсэн гомдол шийдвэрлэсэн байдал, 2014-2020 он



Эх сурвалж: Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт

ёс зүйн хороонд гишүүд болон аудитын компанийн ёс зүйн асуудалтай холбоотой нийт 77 санал гомдол ирснийг хүлээн авч зохих дүрэм, журмын дагуу шийдвэрлэсэн байна. Үүнээс зөрчил биш гэж үзсэн 21, сануулсан 33, эрх хүчингүй болгосон 23 байна (Зураг 1).

Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр татварын мэргэшсэн зөвлөхийн эрх авч татварын мэргэшсэн зөвлөхийн ёс зүйн тангараг өргөсөн нягтлан бодогчдын судалгаа

Татварын мэргэшсэн зөвлөх (ТМЗ)-ийн нийгэмлэг нь 2005 оноос эхлэн татварын хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зөвлөх

үйлчилгээ үзүүлэх эрхийг олгож эхэлсэн байна. 2020 оны байдлаар нийт 1,212 гишүүд, ТМЗ-ийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 73 (эрх нь дууссан 43) гишүүн компани байна (Хүснэгт 3). Эдгээр гишүүд нь “Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай” хуулийн хүрээнд заасан үйл ажиллагааг ТМЗ-ийн нийгэмлэгийн удирдах зөвлөлөөр баталсан “Татварын мэргэшсэн зөвлөхийн ёс зүйн дүрэм”-ийг баримтлан явуулж байна.

ТМЗ-ийн эрх авсан гишүүдийн ёс зүйн тайлан ирүүлсэн байдлыг авч үзвэл 2018 онд 20%, 2019 онд 32%, 2020 онд 38% нь

Хүснэгт 3. Мэргэшсэн зөвлөхийн эрх авсан нягтлан бодогч болон зөвлөх үйлчилгээний эрх авсан компанийн тоо

№	Үзүүлэлт	2005-2016	2017	2018	2019	2020	Нийт
1	Эрх авсан гишүүд	1,322	81	72	147	131	1,753
2	Хүчингүйд зарлагдсан	148	57	50	156	30	441
3	Хүчинтэй гишүүд	1,174	1,198	1,220	1,211	1,312	1,312
1	Эрх авсан компани	52	8	5	4	4	73
2	Хүчингүй болсон						43
3	Хүчинтэй компани						40

Эх сурвалж: ТМЗ-ийн нийгэмлэгийн ажлын алба

Хүснэгт 4. Мэргэшсэн зөвлөхийн татвар төлөлт, эрх сунгалт, ёс зүйн тайлан ирүүлсэн байдал

№	Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
1	Гишүүдийн тоо	1,174	1,198	1,220	1,211	1,312
2	Татвар төлөлт	80%	55%	50%	32%	42%
3	Хугацаандаа эрхээ сунгасан	73%	64%	35%	68%	85%
4	Ёс зүйн тайлан ирүүлсэн	-	1.4%	20%	32%	38%

Эх сурвалж: ТМЗ-ийн нийгэмлэгийн ЁЗХМХ-ны тайлан

ёс зүйн тайлангаа ирүүлсэн байна. Ёс зүйн тайлангаа ирүүлж байгаа гишүүдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай байна (Хүснэгт 4).

ТМЗ-ийн нийгэмлэгийн Ёс зүй, хяналт менежментийн хороо нь ёс зүйн дүрмийг таниулан мөрдүүлэх болон гишүүд, ТМЗ компаниудын ёс зүйтэй холбоотой асуудлыг хүлээн авч шийдвэрлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэйгээр ажилладаг.

2012-2020 оны хооронд ТМЗ-ийн нийгэмлэгийн ЁЗХМХ нь нийт 22 санал, гомдлыг хүлээн авч зохих хууль, дүрэм, журмын дагуу шийдвэрлэсэн байна. Үүнээс хүлээн авах үндэслэлгүй шалтгаанаар буцаасан 8, ажлын байргүй тул хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл олгохыг хойшлуулсан 6, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрлөө давхар ашигласныг мэдэгдэж залруулсан 4, эрхийг түтгэлзүүлэх санал 2, ажлын албанд шилжүүлсэн 2 байна (Зураг 2).

Монголын НББ-ийн хүрээлэнгээс батлан гаргасан мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн тангараг өргөсөн нягтлан бодогчдын судалгаа


Монголын НББ-ийн хүрээлэн (МНББХ)-гийн удирдах зөвлөлийн 2013/03/12-ний өдрийн хурлаар “Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийг батлан гаргасан бөгөөд 2014 оноос эхлэн сайн дурын үндсэн дээр мэргэжлийн нягтлан бодогчдыг нэгдсэн бүртгэлд хамруулан тангараг өргүүлэн ёс зүйн дүрмийг мөрдүүлж байна (Хүснэгт 5).

2020 оны эцсийн байдлаар МНББХ-д тангараг өргөсөн нягтлан бодогчийн ёс зүйтэй холбоотой санал, гомдол, зөрчил бүртгэгдээгүй байна.

Төрийн байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтын үр дүнгийн судалгаа

Төрийн аудитын байгууллагын хийсэн санхүүгийн тайлангийн болон бусад аудитын судалгаа

Зураг 2. ТМЗ-ийн нийгэмлэгт ирсэн гомдол шийдвэрлэсэн байдал 2012-2020 он



Эх сурвалж: Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг ЁЗХМХ-ны тайлан

Хүснэгт 5. Тангараг өргөсөн нягтлан бодогчдын тоо

	2014	2015	2017	Нийт
Тангараг өргөсөн нягтлан бодогчдын тоо	410	139	1,684	2,233

Эх сурвалж: Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн

Санхүүгийн тайлангийн аудит нь үйлчлүүлэгч байгууллагын санхүүгийн тайлан, НББ-ийн гол чухал бодлого ба нэмэлт тайлбар тодруулгуудыг холбогдох санхүүгийн тайлагналын стандартын дагуу үнэн зөв, шударгаар бэлтгэж толилуулсан эсэх талаар гадаад мэдээлэл хэрэглэгчдэд хамгийн дээд түвшний баталгаа өгөх зорилготой нэг төрлийн баталгаажуулах ажил юм (Энх-Амгалан, 2008). Иймд төрийн аудитын байгууллагаас хийж буй санхүүгийн тайлангийн аудит нь тухайн байгууллагын нягтлан бодогчдын ёс зүйг хэмжих нэг үзүүлэлт юм. Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2010-2019 онуудын хооронд Төсвийн ерөнхийлөн захирагчдын нэгтгэсэн болон улсын төсвийн байгууллагын орон нутгийн түвшинд нэгтгэсэн, улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нийт 36,581 санхүүгийн тайланд аудит хийсэн байна (Хүснэгт 6).

Санхүүгийн тайланд хийсэн аудитын шалгалтаар сүүлийн 10 жилийн хугацаанд давхардсан тоогоор нийт 36,581 санхүүгийн тайланд аудит хийснээс 83.6% буюу 30,565 нь зөрчилгүй санал дүгнэлттэй, 14.1% буюу 5,168 нь хязгаарлалтай дүгнэлттэй, 1.6% буюу 601 нь сөрөг дүгнэлттэй, 1.07% буюу

392 нь дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Аудитын шалгалтаар нийт санхүүгийн тайлангийн аудитын 17 орчим хувь нь алдаа дутагдалтай зөрчилтэй байсан ба нийт 79,806.7 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 39,038.3 тэрбум төгрөгийн зөрчлийг залруулж тусгуулсан байна.

Үндэсний аудитын газраас 2018 болон 2019 онуудад 366 гүйцэтгэлийн аудит хийж 9,553 байгууллагыг хамруулсан ба 8,328.9 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлсэн бол тус онуудад 205 нийцлийн аудитын хүрээнд 16,136 байгууллагыг хамруулж 1,305.7 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлсэн байна (Хүснэгт 7).

Төрийн аудитын байгууллагын хийсэн аудитын шалгалтын үр дүн төрийн байгууллагын хувьд тухайн ААНБ-уудын нягтлан бодогч, санхүүгийн ажилчид ёс зүйн зөрчилтэй байгааг илэрхийлж байна.

Татварын албадын ААНБ-уудад хийсэн
татварын хяналт шалгалтаар илэрсэн
зөрчлийн судалгаа

Татварын албаны чиг үүрэгт татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татварын хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих явдал багтсан байдаг. Иймээс татварын албанаас татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах

Хүснэгт 6. Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын шалгалт үр дүн, тэрбум төгрөгөөр

№	Үзүүлэлтүүд	2010-2015	2016	2017	2018	2019	Нийт
1	Хийсэн аудитын тоо: Үүнээс	22,341	3,297	3,179	3,806	3,958	36,581
2	Зөрчилгүй санал дүгнэлт	18,119	2,859	2,848	3,293	3,446	30,565
3	Хязгаарлалтай санал дүгнэлт	3,591	369	294	459	455	5,168
4	Сөрөг санал дүгнэлт	469	42	22	27	41	601
5	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	262	27	15	27	61	392
6	Зөрчлийн дүн	39,503.0	13,939.6	8,110.3	14,006.8	4,247.0	79,806.7
7	Залруулсан зөрчил	17,664.2	5,595.6	2,132.7	12,109.9	1,535.9	39,038.3

Эх сурвалж: УАГ-ын тайлангаас судлаачийн хийсэн тойм

Хүснэгт 7. Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын шалгалтын үр дүн, тэрбум төгрөгөөр

№	Аудитын төрөл	Үзүүлэлт	2018	2019	Нийт
1	Гүйцэтгэлийн аудит	Аудитын тоо	201	165	366
		Хамруулсан байгууллага	6,189	3,364	9,553
		Зөрчлийн дүн	4,191.5	4,137.4	8,328.9
		Залруулсан зөрчил	11.8	-	11.8
2	Нийцлийн аудит	Аудитын тоо	97	108	205
		Хамруулсан байгууллага	8,737	7,399	16,136
		Зөрчлийн дүн	633.1	672.6	1,305.7
		Залруулсан зөрчил	40.3	27.2	67.5

Эх сурвалж: УАГ-ийн тайлангаас судлаачийн хийсэн тойм

зорилгоор ААНБ-уудад 2-5 жилийн хугацаанд төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтуудыг хийж зөрчил, дутагдлыг нь илрүүлэн нөхөн төлбөр, акт торгууль тавьж байна. Энэ шалгалтаар ямар нэгэн байдлаар алдаа, зөрчил илэрч байгаа нь тухайн байгууллагын нягтлан бодогчийн ёс зүйн зөрчлийн илэрхийлэл юм.

Татварын албаны 2013-2020 оны хооронд хийсэн сүүлийн 8 жилийн хяналт шалгалтын дүнгээр илрүүлсэн зөрчлийн нийт тоо 42,216, зөрчлийн мөнгөн дүн нь 31,723.9 тэрбум төгрөг, ногдуулсан төлбөр 2,980.3 тэрбум төгрөг байна. Илрүүлсэн зөрчил нь мөнгөн дүнгээр 2020 онд хамгийн их бөгөөд нийт зөрчлийн 33.9% буюу 10,764.9 тэрбум төгрөг байна. Жил бүрээр хувийн жинг авч үзвэл хамгийн бага зөрчилтэй он нь 2015 он буюу шалгагдсан

нэгжийн 72% нь зөрчилтэй байсан байна (Хүснэгт 8). Татварын албаны хяналт, шалгалтын сүүлийн 8 жилийн нийт дүнгээр хяналт шалгалт хийсэн ААНБ-уудын 82 орчим хувь нь зөрчил илэрсэн байгаа нь нягтлан бодогчдын ёс зүй хангалтгүй түвшинд байгааг илэрхийлж байна.

Төрийн захиргааны төв байгууллагуудаас хийсэн санхүүгийн хяналт шалгалтын үр дүнгийн судалгаа

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар; аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас хэрэгжүүлж байсан санхүүгийн хяналт шалгалтын үндсэн чиг үүргийг 2014 оноос эхлэн Сангийн яам, бусад яамдын хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар, аймаг, нийслэлийн засаг даргад шилжүүлснээр санхүүгийн хяналт,

Хүснэгт 8. Татварын албадын актаар илрүүлсэн зөрчил, ногдуулсан төлбөр, төсөвт оруулсан төлбөр, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Шалгалт хийсэн тоо	11,951	10,050	4,947	5,408	4,999	6,207	5,406	2,338	51,306
Актын тоо	10,600	8,770	3,549	4,138	4,163	5,029	4,357	1,610	42,216
Хувийн жин	88.7%	87.3%	71.7%	76.5%	83.3%	81.0%	80.5%	68.9%	82.3%
Илрүүлсэн зөрчил	1,977.7	3,535.7	523.4	1,348.7	2,979.5	8,005.0	2,589.0	10,764.9	31,723.9
Ногдуулсан төлбөр	212.4	456.8	106.2	110.3	268.7	876.7	182.2	767.0	2,980.3
Төсөвт орсон	59.8	57.8	65.1	27.1	63.6	59.2	60.4	52.0	445.0

Эх сурвалж: ТЕГ-ын Хяналт шалгалт арга зүйн газар

дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээ хийх гэсэн 3 өөр чиг үүргийг нэгтгэсэн холимог бүтэцтэй тогтолцоо бий болсон байна. Ингэснээр санхүүгийн хяналт шалгалтын бодлого зорилтыг Сангийн яам тодорхойлж Засгийн газрын нэрийн өмнөөс гүйцэтгэх засаглалын санхүүгийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байна. Санхүүгийн хяналт шалгалтыг ЗГХЭГ, яам, аймаг, нийслэлийн санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторуд гүйцэтгэж байна (legalinfo.mn).

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын 2016-2019 онуудад хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдлын судалгааг авч үзвэл дараах байдалтай байна (Хүснэгт 9).

Санхүүгийн хяналт шалгалтаар 2016-2019 онуудын нийт 2,810 албан шаардлага, 9,790 акт, 991,854.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн бөгөөд илрүүлж байгаа нийт зөрчлийн дүн нь сүүлийн жилүүдэд өссөн хандлагатай байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг шийдвэрлэсэн байдлыг авч

үзвэл 2018 онд 17,452.6 сая төгрөг, 2019 онд 22,404.5 сая төгрөгийн зөрчлийг шийдвэрлэсэн байна (Хүснэгт 10). Хоёр жилийн хугацаанд нийт шийдвэрлэсэн зөрчлийн 63.3%-ийг улсын төсөвт, 20.5%-ийг тухайн байгууллагад, 13.2%-ийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 3.0%-ийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна. Санхүүгийн хяналт шалгалтын үр дүнгийн судалгаа нь ёс зүйн зөрчил гарч байгааг илэрхийлж байна.

Нийгмийн даатгалын байгууллагаас ААНБ-уудад хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн судалгаа

Нийгмийн даатгалын байгууллагын үндсэн чиг үүрэг нь нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах явдал юм. Энэ хүрээнд ААНБ-уудад нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт, шалгалтын ажлыг хийж байна. Сүүлийн 5 жилийн хяналт, шалгалтын үр дүнг авч үзвэл дараах байдалтай байна (Хүснэгт 11).

Нийгмийн даатгалын байгууллагаас ААНБ-уудад хийсэн хяналт, шалгалтын

Хүснэгт 9. Санхүүгийн хяналт шалгалтын албан шаардлага, актын тоо, илрүүлсэн зөрчлийн дүн, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	Нийт
Албан шаардлагын тоо	686	727	708	689	2,810
Актын тоо	2,428	2,630	2,502	2,230	9,790
Нийт зөрчлийн дүн	59,324.6	188,022.4	365,694.0	378,813.8	991,854.8

Эх сурвалж: Сангийн яамны СХЭУГ

Хүснэгт 10. Санхүүгийн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг шийдвэрлэсэн байдал, 2018-2019 он, сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	2018		2019		Нийт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Нийт шийдвэрлэсэн зөрчил	17,452.6	100%	22,404.5	100%	39,857.1	100%
2	Улсын төсөвт	11,078.0	63.5%	14,144.8	63.1%	25,222.8	63.3%
3	Тухайн байгууллагад	4,365.2	25.0%	3,795.0	16.9%	8,160.2	20.5%
4	Орон нутгийн төсөвт	1,456.6	8.3%	3,795.0	16.9%	5,251.6	13.2%
5	Хуулийн байгууллагад шилжүүлсэн	545.5	3.1%	669.7	3.0%	1,215.2	3.0%
6	Барагдуулсан торгууль	7.3	0.1%	-	-	7.3	-

Эх сурвалж: Сангийн яамны СХЭУГ

Хүснэгт 11. Нийгмийн даатгалын байгууллагаас 2010-2016 оны актаар илрүүлсэн зөрчил, сая төгрөгөөр

№	Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	Нийт
1	Тавигдсан акт тоо	150	169	120	38	54	531
2	Илрүүлсэн зөрчил, сая ₮	309.6	2,133.8	887.8	281.5	1,051.3	4,664.0

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

сүүлийн 5 жилийн нийт дүнгээр 4,664.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 531 ААНБ-д акт тавьсан байна.

Төрийн байгууллагуудын хийсэн хяналт шалгалтуудын гол объект нь НББ-ийн баримт бичиг байдаг тул дээрх судалгаануудын үр дүн нь тухайн байгууллагын нягтлан бодогчид болон санхүүгийн ажилтнууд ёс зүйн зөрчил гаргаж байгааг илэрхийлж байна.

Их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт НББ мэргэжлийн ёс зүйн хичээлийн талаар хийсэн судалгаа

Монгол Улсын хэмжээнд дээд боловсролын салбарт сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг 88 их, дээд сургууль (ИДС), коллеж байгаагаас НББ-ийн хөтөлбөрөөр сургалт явуулдаг 45 ИДС, коллеж байна. Үүнээс бакалаврын сургалтыг 45, магистрын сургалтыг 11, докторын сургалтыг 3 ИДС явуулж байна. Нягтлан бодогчдоод НББ мэргэжлийн ёс зүйн тухай ойлголтыг түгээх эхний мэдээллийн эх үүсвэр нь ИДС юм. НББ мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж буй ИДС нь мэргэжлийн хүрээн дэх ёс зүйн ухагдахууныг оюутан суралцагчдад ойлгуулсан байх, мөн ёс зүйн асуудлаас үүсэх хариуцлага, үр дагаварын талаарх мэдэгдэхүүнийг орсон байх гэсэн таамаглал дээрээ үндэслэн НББ мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг томоохон ИДС болон мэргэжлийн зэрэг олгох сургалтанд мэргэжлийн ёс зүйн хичээл ордог эсэх талаар судалгаа авсан бөгөөд судалгаанд 17 ИДС, 2 мэргэжлийн төрийн бус байгууллагыг хамруулсан

(Хүснэгт 12).

Судалгаанаас харахад нийт 17 ИДС-иудаас 10 сургууль нь НББ-ийн мэргэжлийн ёс зүйн тусгайлан хичээлийг сургалтын төлөвлөгөөндөө тусган зааж байна. Бусад 7 сургууль нь мэргэжлийн ёс зүйн тусгайлсан хичээл ордоггүй боловч ёс зүй, бизнесийн ёс зүй, харилцааны ёс зүй зэрэг хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөндөө тусган орж байна. Эндээс харахад ИДС-иудыг нягтлан бодогч мэргэжлээр төгсөгч оюутнуудын хувьд мэргэжлийн ёс зүйн мэдлэг, мэдээллийг харилцан адилгүй авч байна. ММНБИ болон ТМЗ-ийн нийгэмлэг нь эрх олгох болон эрх сунгах сургалтууддаа заавал судлах мэргэжлийн ёс зүйн 4-16 цагийн хичээлийг орж байна.

Нягтлан бодогчдоос авсан мэргэжлийн ёс зүйн ойлголт, хандлагад хийсэн судалгаа

Судалгаанд нийт 188 нягтлан бодогч хамрагдсан бөгөөд үүнээс албан тушаалын хувьд 10.6% нь санхүүгийн албаны дарга, 27.7% нь ерөнхий нягтлан бодогч, 40.4% нь тооцооны нягтлан бодогч, 21.3% нь бусад санхүүгийн ажилтнууд хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 86.2% нь эмэгтэй, 13.8% нь эрэгтэй байна. Ажилласан жилийн хувьд 52.1% нь 0-5 жил, 23.3% нь 6-10 жил, 25.6% нь 11-ээс дээш жил нягтлан бодогч болон санхүүгийн ажилтнаар ажилласан бөгөөд мэргэжлийн хувьд авч үзвэл 83% нягтлан бодогч, 17% нь санхүү, эдийн засаг болон бусад мэргэжлийн хүмүүс байна.

Хүснэгт 12. Их, дээд сургуулиуд болон мэргэжлийн байгууллагын хөтөлбөрийн харьцуулалт

№	Их, дээд сургууль	Хичээлийн нэр	Кт цаг	Судлах хэлбэр	Тайлбар
1	Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль	НББОУС, мэргэжлийн ёс зүй	3 кт	Заавал судлах	12 цагийн НББ-ийн ёс зүйн хичээл ордог.
2	МУИС - Бизнесийн сургууль	Бизнесийн ёс зүй	3 кт	Заавал судлах	12 цагийн НББ-ийн ёс зүйн хичээл ордог.
3	Мандах их сургууль	Мэргэжлийн удиртгал Бизнесийн харилцаа, ёс зүй Бизнесийн эрх зүй	1 кт 1 кт 1 кт	Заавал судлах	
4	Хүмүүнлэгийн ухааны их сургууль	НББОУС, мэргэжлийн ёс зүй	3 кт	Заавал судлах	12 цагийн НББ-ийн ёс зүйн хичээл ордог.
5	Олон улсын эдийн засаг бизнесийн дээд сургууль	Мэргэжлийн ёс зүй	2.5 кт	Заавал судлах	
6	Отгонтэнгэр их сургууль	Мэргэжлийн ёс зүй	2 кт	Заавал судлах	Төгсөх ангид орох
7	Их засаг олон улсын их сургууль	НББ-ийн мэргэжлийн ёс зүй	2 кт	Заавал судлах	24 цагийн лекц, 16 цагийн семинар
8	Ховд их сургууль	Мэргэжлийн ёс зүй	2 кт	Сонгон судлах	24 цагийн лекц, 16 цагийн семинар
9	Сан их сургууль	Мэргэжлийн ёс зүй	3 кт	Заавал судлах	32 цагийн лекц, 32 цагийн семинар
10	Монголын хүний нөөцийн удирдлагын дээд сургууль	Санхүүгийн тайлагналын стандарт, мэргэжлийн ёс зүй	3 кт	Заавал судлах	1 кт цагийн ёс зүйн хичээл ордог.
11	Санхүү эдийн засгийн их сургууль	Тусгайлсан хичээл ордоггүй	-	-	
12	ХААИС-Эдийн засаг бизнесийн сургууль	Тусгайлсан хичээл ордоггүй	-	-	
13	Монголын үндэсний их сургууль	Тусгайлсан хичээл ордоггүй	-	-	
14	Этүгэн их сургууль	Тусгайлсан хичээл ордоггүй	-	-	
15	Орхон их сургууль	Тусгайлсан хичээл ордоггүй	-	-	
16	Идэр их сургууль	Тусгайлсан хичээл ордоггүй	-	-	
17	Глобал удирдагч дээд сургууль	Тусгайлсан хичээл ордоггүй	-	-	
18	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт	- Эрх олгох сургалт - Эрх сунгах сургалт	18 цаг 6 цаг	Заавал судлах	Сургалтанд хамрагдаж буй бүх нягтлан бодогчид
19	Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэг	- Эрх сунгах сургалт	4 цаг	Заавал судлах	Сургалтанд хамрагдаж буй бүх нягтлан бодогчид

Эх сурвалж: Судлаачийн хийсэн тойм

Судалгаанд хамрагдсан нягтлан бодогчдын 76.6% нь мэргэжлийн ёс зүйн хичээлийг өмнө нь судалж байсан бол 23.4% нь ёс зүйн хичээл судалж байгаагүй гэсэн хариулт өгсөн байна.

Ёс зүйн дүрмийн талаар сургалт, мэдээлэл авах хэрэгцээ шаардлага байна уу гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нягтлан бодогчдын 81% нь тийм, 19% нь үгүй гэж хариулсан байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Судалгааны асуулга, хариулт

№	Судалгааны асуулга	Хариулт			
		Тийм		Үгүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Их, дээд сургууль болон бусад мэргэжлийн сургалтуудад мэргэжлийн ёс зүйн хичээл судалж байсан уу.	144	76.6%	44	23.4%
2	Танд ёс зүйн дүрмийн талаар сургалт, мэдээлэл авах хэрэгцээ шаардлага байна уу ?	152	80.9%	36	19.1%

Эх сурвалж: Судлаачийн хийсэн тойм

Хүснэгт 14. Судалгааны асуулга, хариулт

№	Судалгааны асуулга	Хариулт					
		Сайн		Дунд		Муу	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Та өөрийгөө нягтлан бодогчийн мэргэжлийн ёс зүйн талаар хэр зэрэг ойлголттой гэж бодож байна вэ?	100	53.2%	78	41.5%	10	5.3%
2	Ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар хэр зэрэг ойлголттой вэ?	44	23.4%	128	68.1%	16	8.5%

Эх сурвалж: Судлаачийн хийсэн тойм

Хүснэгт 15. Судалгааны асуулга, хариулт

№	Судалгааны асуулга	Хариулт			
		Тийм		Үгүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Та өмнө нь гаргасан санхүүгийн болон татварын тайлангаа дахин засварлах шаардлага гарч байсан уу?	150	79.7%	38	20.2%

Эх сурвалж: Судлаачийн хийсэн тойм

Ёс зүйн дүрмийн талаар хэр зэрэг ойлголттой вэ? гэсэн асуултанд 53.2% нь сайн, 41.5% нь дунд, 5.3% нь муу гэсэн хариулт өгсөн байна. Ёс зүйн зөрчил гаргасан үед хүлээлгэх үүрэг хариуцлагын талаар хэр зэрэг ойлголттой вэ? гэсэн асуултанд 23.4% нь сайн, 68.1% нь дунд, 8.5% нь муу гэж хариулсан байна (Хүснэгт 14).

Өмнө нь гаргасан тайлангаа дахин засварлаж байсан уу гэсэн асуултанд 150 нягтлан бодогч буюу 80 орчим хувь нь тийм гэсэн хариулт өгсөн байна (Хүснэгт 15). Энэ үр дүнгээс харахад судалгаанд

хамрагдсан ихэнх нягтлан бодогчид өмнө нь алдаатай тайлан бэлтгэж байсан байна.

Алдаатай тайлан бэлтгэхэд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсийг удирдлагын нөлөөлөл, мэргэжлийн ур чадвар, санамсаргүй байдал, хувийн ашиг сонирхол гэж үзсэн байна (Хүснэгт 16).

Нийт судалгаанд оролцогчдын хувьд хандлага ба ёс зүйг I, мэргэжлийн ур чадварыг II, багаар ажиллах чадварыг III, гадаад хэлний мэдлэгийг IV гэж эрэмбэлсэн байна. Энэ үр дүн нь хамгийн чухал шаардлага бол хандлага ба ёс зүй гэсэн дүгнэлт гарч байна.

Хүснэгт 16. Нягтлан бодогчид алдаатай тайлан бэлтгэхэд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлүүдийг эрэмбэлнэ үү.

№	Нөлөөллүүд	Эрэмбэ	Хариулт
1	Удирдлага болон дээд албан тушаалтны нөлөөлөл	I	78
2	Мэргэжлийн ур чадвар дутмаг байдал	II	64
3	Санамсаргүй байдал	III	62
4	Хувийн ашиг сонирхол	IV	52
5	Хүлээх үүрэг хариуцлага бага	V	62
6	Хяналт шалгалт сул	VI	50
7	Танилын нөлөөлөл	VII	72

Эх сурвалж: Судлаачийн хийсэн тойм

Хүснэгт 17. Танай байгууллага нягтлан бодогч шинээр ажилд авах бол таны хувьд дараах шаардлагуудаас алийг нь чухалчлах вэ? (Эрэмбэлнэ үү)

№	Шаардлагууд	Эрэмбэ	Хариулт
1	Хандлага ба ёс зүй	I	102
2	Мэргэжлийн ур чадвар	II	80
3	Багаар ажиллах чадвар	III	50
4	Гадаад хэлний мэдлэг	IV	74

Эх сурвалж: Судлаачийн хийсэн тойм

Дүгнэлт, санал зөвлөмж

Манай улсын хувьд мэргэжлийн байгууллагуудаас батлан гаргасан нягтлан бодогчдын үйл ажиллагаанд баримтлах нийтлэг ёс зүйн дүрэм багагүй байгаа боловч тэдгээрийн хэрэгжилт хангалтгүй, ёс зүйн дүрмийн талаар нягтлан бодогчдын мэдлэг мэдээлэл дутмаг, санаатай болон санамсаргүй алдаатай санхүүгийн тайлан бэлтгэх байдал багагүй түвшинд байгааг дээрх судалгааны үр дүнгүүд харуулж байна. Судалгааны үр дүнг хийсэн судалгаа бүрээр дүгнэвэл:

1. Ёс зүйн дүрэм батлан мөрдүүлдэг мэргэжлийн байгууллагууд болох ММНБИ, ТМЗ-ийн нийгэмлэг, МНБХ гэсэн 3 байгууллагын гишүүнчлэлд нийт 8,276 гишүүн, 178 ААНБ харъяалагдан үйл ажиллагаа явуулж байна. ММНБИ-ийн Аудит, ёс зүйн хороо нь 2020 оны байдлаар нийт гишүүдийн 66.4%-ийн ёс зүйн тайланг хүлээн авсан ба 2014-2020 оны хооронд ёс зүйн зөрчилтэй холбоотой 77 гомдол хүлээн авч шийдвэрлэсэн байна. ТМЗ-ийн

нийгэмлэгийн ЁЗХМХ нь 2020 онд нийт гишүүдийн 38% буюу 498 гишүүний ёс зүйн тайланг хүлээн авсан байна. 2012-2020 оны хооронд гишүүдийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 22 гомдлыг хүлээн авч зохих дүрэм, журмын дагуу шийдвэрлэсэн байна. МНБХ нь 2014 оноос эхлэн нийт 2,233 нягтлан бодогчдыг сайн дурын үндсэн дээр гишүүнчлэлд хамруулан ёс зүйн тангараг өргүүлсэн хэдий ч одоогийн байдлаар гишүүдийн ёс зүйн зөрчилтэй холбоотой санал, гомдол хүлээн аваагүй байна.

2. Аудитын байгууллагын шалгалтаар сүүлийн 10 жилийн хугацаанд давхардсан тоогоор нийт дүнгээр 36,581 санхүүгийн тайлангийн аудит хийсний 17 орчим хувь нь зөрчилтэй ба 79,806.7 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Мөн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын шалгалтаар 2018, 2019 онуудад нийт 9,634.6 төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Татварын албаны сүүлийн 8 жилийн

хяналт шалгалтын дүнгээр 51,306 ААНБ-д шалгалт хийсний 82% буюу 42,216 нь зөрчилтэй, зөрчлийн мөнгөн дүн нь 31,723.9 тэрбум төгрөг байна. Санхүүгийн хяналт шалгалтаар 2016-2019 онуудын нийт 2,810 албан шаардлага, 9,790 акт, 991,854.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн бол нийгмийн даатгалын байгууллагаас 2013-2017 оны хооронд ААНБ-д хийсэн хяналт, шалгалтын 5 жилийн нийт дүнгээр 4,664.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 531 ААНБ-д акт тавьсан байна. Энэ судалгааны үр дүнгүүд нь нягтлан бодогчид болон санхүүгийн ажилтнууд ёс зүйн зөрчил гаргаж байгааг илэрхийлж байна.

3. Томоохон ИДС-иудын сургалтын хөтөлбөрт хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан сургуулиудын 59% нь ёс зүйн хичээлийг зааж байгаа бол 41% нь ёс зүйн хичээлийг орохгүй байна. Иймд төгсөж байгаа төгсөгчид маань мэргэжлийн ёс зүйн талаарх ойлголт хангалтгүй байгааг илэрхийлж байна.
4. Нягтлан бодогчдоос авсан судалгааны үр дүнгээр 76.6% нь мэргэжлийн ёс зүйн хичээлийг өмнө нь судалж байсан, 53.2% нь мэргэжлийн ёс зүйн талаарх ойлголт сайн, 81% нь ёс зүйн дүрмийн талаар сургалт, мэдээлэл авах хэрэгцээ шаардлагатай, 23.4% нь ёс зүйн зөрчил гаргасан үед хүлээлгэх үүрэг хариуцлагыг сайн мэднэ, 80% нь өмнө гаргасан тайлангаа дахин засварлаж байсан зэрэг хариулт

өгсөн байна. Эдгээр үр дүнгээс харахад нягтлан бодогчдын ёс зүйн талаарх ойлголт хангалтгүй, ёс зүйн дүрмийг зөрчиж байгаа нь харагдаж байна. Алдаатай тайлан бэлтгэхэд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлсийг удирдлагын нөлөөлөл, мэргэжлийн ур чадвар, санамсаргүй байдал, хувийн ашиг сонирхол гэж үзсэн байна. Нийт судалгаанд оролцогчдын хувьд шинэ ажилтанд тавигдах шаардлагуудаас хандлага ба ёс зүйг I, мэргэжлийн ур чадварыг II, багаар ажиллах чадварыг III, гадаад хэлний мэдлэгийг IV гэж эрэмбэлсэн байна. Энэ үр дүн нь хамгийн чухал шаардлага бол хандлага ба ёс зүй гэсэн дүгнэлт гарч байна.

Дээрх дүгнэлтүүдийг үндэслэн дараах санал, зөвлөмжүүдийг дэвшүүлж байна. Үүнд:

- НББ-ийн мэргэжилтэн бэлтгэж байгаа ИДС болон сургалтын байгууллагуудын сургалтын төлөвлөгөөнд ёс зүйн хичээлийг заавал судлах хичээлээр тусгуулах.
- Мэргэжлээрээ ажиллаж байгаа нягтлан бодогчид болон байгууллагын удирдлагуудад ёс зүйн мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг мэргэжлийн байгууллагуудаас тогтмол зохион байгуулж байх.
- Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил болон буруутай этгээдэд хүлээлгэсэн хариуцлагын талаар тухай бүр нийтэд мэдээлдэг байх.

Ашигласан материал

- Akadakpo, B, A. (2013). Ethical Practices of the Professional Accountant in Nigeria. *Research Journal of Finance and Accounting*, 4(7), 59-66.
- Авлигатай тэмцэх газар (2019). *Төрийн албан хаагчийн ёс зүй” гарын авлага*. Улаанбаатар.
- Агваан, Н. (2016). *Нягтлан бодогч мэргэжлийн ёс зүй*. Улаанбаатар, Соёмбо принтинг ХХК.
- Гантулга, Г. (2018). *Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанарыг үнэлэх нь*. Улаанбаатар.
- Дамбадорж, Л. (2008). *Төгсөх ангийнханд болон дипломын дараа суралцагчдад*. Улаанбаатар.
- Дарьхүү, Р. (2018). Ёс зүй ба ёс суртахуун. *Хэрэглээний стандарт*, 01/098.
- Дарьхүү, Р. (2018). Ёс суртахууны энгийн хэм хэмжээ, түүний ач холбогдол. *Хэрэглээний стандарт*, 03/100.
- ДБ болон МУСЯ (2017). *Монгол Улсын Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нэвтрэлт*, судалгааны тайлан.
- ММНБИ (2008). *Санхүүгийн тайлагналын гарын авлага*. Улаанбаатар.
- ММНБИ (2016). *Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм*. Улаанбаатар.
- ММНБИ (2021). *Нягтлан бодогчийн ёс зүйн олон улсын дүрэм*. Улаанбаатар.
- МНББХ (2013). *Мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм*. Улаанбаатар.
- Оюунчимэг, Б. (2011). *Бизнесийн ёс зүй*. Улаанбаатар, Бодьмөр принтинг ХХК.
- ТМЗН (2017). *Татварын мэргэшсэн зөвлөхийн ёс зүйн дүрэм*. Улаанбаатар.
- Тунгалаг, Д. (2015). *Ёс зүйн зангилаа асуудлууд*. Улаанбаатар.
- Энхбат, А., Янжинсүрэн, Г. (2020). *Төрийн (нийтийн) төсөв, санхүүгийн хяналт шалгалт: Онол, практик, арга зүй, тогтолцоо, эрх зүйн орчин*. Улаанбаатар.